



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 1 дүгээр сарын 16-ны  
өдөр

Улаанбаатар хот

### Дугаар 27 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, АСАРГААНЫ ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Нийгмийн халамжийн тухай хуулийн 16.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

- Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг сард 174,000 (нэг зуун далан дөрвөн мянган) төгрөгөөр, асаргааны тэтгэмжийн хэмжээг сард 76,000 (далан зургаан мянган) төгрөгөөр тус тус тогтоон мөрдсүгэй.
- Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 17 дугаар тогтоолын 1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.
- Энэ тогтоолыг 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд

С.ЧИНЗОРИГ